

ДАМЖУУЛАН ОЛГОХ ТӨСЛИЙН ЗЭЭЛҮҮДИЙН 2018 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН

Монголбанкнаас дамжуулан олгож буй төслийн зээлүүдийн тайланг улирал бүр гаргаж, Монголбанкны вэб хуудсанд байршуулах ажлын хүрээнд 2018 оны 3 дугаар улирлын тайланг танилцуулж байна.

Монгол улсын Засгийн газар 1994 онд Азийн хөгжлийн банктай, 1995 онд ХБНГУ-ын Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу Монголбанк КфВ банк болон АХБ-ны төслийн зээлийг банкуудад дамжуулан олгох үүрэгтэй оролцож байна.

1. КфВ банкны ЖДҮ-ийг дэмжих төслийн зээл

Төслийн зорилго: Боловсруулах үйлдвэрлэл, Хөдөө аж ахуйн чиглэлийн ЖДҮ-ийг хөгжүүлэх, санхүүгийн секторыг дэмжих.

Эх үүсвэр: Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 40 жилийн хугацаатай 8.7 сая еврогийн зээлийг жилийн 0.75 хувийн хүүтэйгээр хүлээн авсан.

КфВ банкнаас Монголбанкинд олгосон зээлийн эргэн төлөлт: Монголбанк КфВ банкинд жилд 2 удаа хуваарийн дагуу эргэн төлөлт хийдэг бөгөөд анх зээл авсанаас хойш нийт 2.9 сая еврог КфВ банкинд төлсөн. Ингэснээр энэхүү зээлийн үлдэгдэл 2018 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар 5.76 сая евро байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. КфВ төслийн зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл /евро/

	2017.III	2017.IV	2018.I	2018.II	2018.III
Эхний үлдэгдэл	6 043 562,26	6 043 562,26	5 901 710,39	5 901 710,39	5 759 858,52
Үндсэн зээлийн төлбөр	-	141 851,87	-	141 851,87	-
Хүүгийн төлбөр	-	22 663,36	-	22 131,41	-
Эцсийн үлдэгдэл	6 043 562,26	5 901 710,39	5 901 710,39	5 759 858,52	5 759 858,52

Монголбанкнаас Банкинд олгосон зээл: Банкуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монголбанк 500 000 000 төгрөг хүртэлх санхүүжилтийг 5 жилийн хугацаатай банкуудаар дамжуулан олгодог. Банк зээлийн эргэн төлөлтийг Монголбанкинд жилд 2 удаа хуваарийн дагуу төлдөг бөгөөд 2018 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар оролцогч банкуудаар дамжуулан олгосон зээлийн үлдэгдэл 3.4 сая евро /10.1 тэрбум төгрөг/* байна (Зураг1).

Зураг 1. КфВ төслийн зээлийн үлдэгдэл, дамжуулан олгосон дүн



Эх үүсвэрийн ашиглалт: Тайлант хугацааны эцсийн байдлаар хөтөлбөрийн эргэлтийн сангийн хөрөнгийн 59.4 хувийг дамжуулан олгосон байна. КфВ төслийн ашиглаагүй эх үүсвэрийн үлдэгдэл 2018 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар 2.34 сая евро буюу 6.9 тэрбум төгрөг* байна (Зураг1).

Банкуудын ААН-д олгосон зээл: КфВ банкны төсөл манай улсад хэрэгжиж эхэлснээс хойш уг төсөлд нийт 171 ЖДҮ зээлд хамрагдаж, 85.4 тэрбум төгрөгийн* хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл авсан байна. Тайлант улирлын эцсийн байдлаар 65 ЖДҮ эрхлэгч ААН-үүд 10.1 тэрбум төгрөг /3.4 сая евро/-ийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нэг зээлдэгчид ногдож буй зээлийн дундаж хэмжээ 156.1 сая төгрөг байна.

2. АХБ-ны Ажлын байр нэмэгдүүлэх (АБН) төслийн зээл

Төслийн зорилго: Монгол улс, АХБ-ны хооронд байгуулсан зээлийн хэлэлцээрийн зорилго нь хувиараа хөдөлмөр эрхлэх хэлбэрээр жижиг үйлдвэрлэл эрхэлж буй иргэдийг дэмжих, мөн ажлын байр нэмэгдүүлэхэд оршино.

Эх үүсвэр: Монгол Улс, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу 2154.0 мянган зээлжих тусгай эрхтэй (ЗТЭ) тэнцэх валютыг 40 жилийн хугацаатай зээлсэн.

АХБ-наас Монголбанкинд олгосон зээлийн эргэн төлөлт: Монголбанк АХБ-нд жилд 2 удаа хуваарийн дагуу эргэн төлөлт хийдэг бөгөөд хамгийн сүүлд 2018 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр 40,800.00 ЗТЭ эргүүлэн төлсөн. Анх зээл авснаас хойш нийт 930.5 мянган ЗТЭ-ийг төлсөнөөр 2018 оны 3 дугаар улирлын эцсийн байдлаар зээлийн өрийн үлдэгдэл 1,223.5 мянган ЗТЭ буюу 4.38 тэрбум төгрөг* байна (Хүснэгт 2).

* 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн ханшаар тооцов.

Хүснэгт 2. АХБ-ны АБН төслийн зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл /ЗТЭ/

	2017.II	2017.IV	2018.I	2018.II	2018.III
Эхний үлдэгдэл	1 345 917,68	1 305 117,68	1 305 117,68	1 264 317,68	1 264 317,68
Үндсэн зээлийн төлбөр	40 800,00	-	40 800,00	-	40 800,00
Хүүгийн төлбөр	6 729,58	-	6 525,59	-	6 321,59
Эцсийн үлдэгдэл	1 305 117,68	1 305 117,68	1 264 317,68	1 264 317,68	1 223 517,68

Банкинд дамжуулан олгосон зээл: Монголбанк төсөлд оролцогч Голомт, Улаанбаатар хотын банк дээр нэмж Ариг, ҮХО, Богд банкуудыг оролцуулахаар 2018 оны 7 дугаар сарын 23-ны өдөр “Санхүүжилтийн гэрээ”-г байгуулсан. Банкуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монголбанк 30 сая төгрөг хүртэлх санхүүжилтийг 2 жилийн хугацаатай банкуудаар дамжуулан олгож байна.

Тайлант улирлын эцсийн байдлаар төслийн хүрээнд банкуудад дамжуулан олгосон эх үүсвэрийн үлдэгдэл 1.5 тэрбум төгрөг байгаа бөгөөд эргэлтийн санд зээлдүүлэх боломжит эх үүсвэр 2.87 тэрбум төгрөг* байна (Зураг 2).

Зураг 2. АХБ-ны АБН төслийн зээлийн үлдэгдэл, дамжуулан олгосон дүн, төгрөгөөр



Банкуудын тайлангаас үзэхэд 2018 оны 3 дугаар улирлын байдлаар зээл олгосон 67 аж ахуй нэгж нийт 219 ажлын байр бий болгосон байна.